ДУНДГОВЬ АЙМАГ
**ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 23 өдөр Дугаар А/155 Сангийндалай

Хортон мэргэчидтэй тэмцэх зардал
гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.13 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын нутаг дэвсгэрт үлийн цагаан оготнотой тэмцэх, хор цацах, шувууны суулт хийх ажлыг М.Ганзориг ахлагчтай бүлэгтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Уг ажилтай холбогдон гарах зардал 20,000,000 (хорин сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Энхбат)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавин ажиллахыг Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (И.Дүрзээ), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА

482302109